

“ТОРГОХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ”

SOME PROBLEMS OF LEGAL REGULATION OF PENALTIES



Б.Уянга

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн багш, дэслэгч

Товч утга: Монгол улсын эрүүгийн хуулийн хэрэглээ, торгох ялын биелэлт, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, гэмт хэрэг болон гэм буруутай этгээдийн хувийн байдалд тохирсон эрүүгийн хариуцлага оногдуулах нь ялын биелэлттэй хамааралтай тул хууль тогтоомжийн холбогдох заалтыг цаашид боловсронгуй болгох шаардлага үүсэж байна.

Abstract: When a person convicted of a crime is sentenced to a fine according to the special class of the Criminal Code, the issues of application of the law in the sentencing process, the execution of the fine, and the imposition of criminal responsibility appropriate to the crime and the personality of the guilty person are related to the execution of the sentence. there is a need for further improvement.

Түлхүүр үг: Эрүүгийн хууль, торгох ял, шийтгэх тогтоол, эрх зүйн шинэчлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа.

Keywords: Criminal law, fines, sentencing, legal reform, criminal procedure.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Монгол Улсын хууль цаазын их өв уламжлалд эд хөрөнгийн шинжтэй эрүүгийн хариуцлагын талаар хэрхэн зохицуулсан байдлыг судалж үзэхэд “Их засаг хууль, Их Юань гүрний нэвтэрхий хууль, Монгол Ойрадын хууль, Халх журам, Монгол зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичигт есөөр торгох, ор босгох, малаар торгох зэрэг эд хөрөнгийн шинжтэй торгуулийн ялыг оногдуулж ирсэн нь түүхэн эх сурвалжид тэмдэглэгдэн үлджээ” (С.Нарангэрэл, 2007, хууд. 26).

“Ардын хувьсгалаас хойш 1926 оны Шүүх цаазын бичигт эдийн засгийн хэмжигдэхүүн болох мөнгөн төлбөрийн хэлбэрээр торгуулийн хэмжээг 50-1800 төгрөг, 1942 оны Эрүүгийн хуульд 200-1000 төгрөг, 1986 оны Эрүүгийн хуульд 1500-2250 төгрөг тусгай ангид заасан бол 5000 хүртэл төгрөг, 1993 оны нэмэлт өөрчлөлтөөр 2000-250.000 төгрөг тусгай ангид заасан тохиолдолд 500.000 төгрөг

хүртэл торгох ял оногдуулахаар заасан байна. Харин 2002 оны Эрүүгийн хуулиар торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэгдэх үеийн Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тогтоосон байна. Гэвч 2002 оноос хойш өнөөдрийг хүртэл Засгийн газрын шийдвэрийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 13 удаа шинэчлэгдэн тогтоогдсоны улмаас торгох ялын хэмжээ тухай бүр өөрчлөгдсөөр иржээ” (С.Жанцан, 2009)

Харин өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2015 оны Эрүүгийн хуулиар торгох ялыг тооцох нэгжийн хэмжээг 1000 төгрөгөөр тогтоож, гэмт хэрэг үйлдсэн хүнд 100-40.000 нэгжтэй, хуулийн этгээдэд 10.000-400.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн торгууль оногдуулж болохоор нарийвчлан хуульчилсан ба цаашид нэгжийн хэмжээг өөрчлөх эрхийг эдийн засгийн байдлыг харгалзан хууль санаачлах эрх бүхий этгээд санаачилсны дагуу хууль тогтоогч буюу Монгол Улсын Их хурал эдлэхээр зохицуулалт хийжээ.

Торгох ял бол Монголын эрүүгийн эрх зүй дэх хамгийн хөнгөн, уламжлалт, өргөн хэрэглэгддэг ялын төрөл юм. ЭХ-д торгох ялыг гагцхүү үндсэн ялаар хэрэглэхээр заасан. Торгох ялыг ногдуулах түвшин хүмүүсийн амьдралын нийгэм-эдийн засгийн нөхцөл, тэдний төлбөрийн чадвараас тодорхой хэмжээгээр шалтгаалдгийг практик харуулж байна. “2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгжтэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ гэж тодорхойлжээ. Энэхүү ялын төрөл нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нэг удаа оногдуулдаг. Шүүгдэгчийн эдийн засгийн болон эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг хөнддөг харин бусад эрх, эрх чөлөөнд ямар нэг хязгаарлалт тогтоодоггүй. Тэнсэж болдоггүй шүүх торгох ялыг 3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болдог. Хэрэв шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоногоор тооцож хорих ялаар сольдог” (УИХ, 2016) зэрэг онцлогтой ялын нэгэн төрөл юм.

Монгол Улс эрүүгийн ялын бодлогыг дэлхийн нийтийн жишигт нийцүүлж “Хорихоос өөр төрлийн ялын төрлийг нэмэгдүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, нийгмийн гишүүдийн дунд нийгэмших, тэдэнд боломж олгох, хяналт тавих, ялын тогтолцооны хүрээнд “альтернатив” шинжийг харгалзаж, ялын бодлогын хувьд хүний эрх, энэрэнгүй ёсны зарчимд тулгуурласан, хорих ялаас хөнгөн шинж чанартай байдалд нь үндэслэж, сонгох санкц болж буй нөхцөлд торгох ялыг түлхүү оногдуулах болсон билээ” (С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, 2019)

Ял, шийтгэлийн бодлого нь “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, хийдэлгүй байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой байдаг тул ял шийтгэлийн төрлийг өөрчлөх, нэмж хассан нь чухал бус харин ялын дээд, доод


хэмжээ, тэдгээрийн тохироо, ялаас чөлөөлөх, хөнгөрүүлж оногдуулах үндэслэл, журам оновчтой байх болон тухайн ялыг хэрэгжүүлэх бүх талын бодит боломж буюу ялын хэрэгжилт, үр нөлөө хамгийн чухал шалгуур болдог” (ШШГЕГ, 2017, хуудсд. 5-25)

Монгол Улсын 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд зааснаар “торгох ялыг хуулийн этгээд, гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулахаар заасан байна. Монгол Улсын хувьд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал хуульчлагдсан байдал нь 2002 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар эхэлсэн гэж үзэх үндэслэлтэй бөгөөд 2002 онд 2 төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага буюу торгох ял оногдуулахаар” (УИХ, 2016) хуульчилсан нь энэхүү ялын оновчтой зохицуулалт болсон билээ.

Академич С.Нарангэрэл “Гэмт буруутай этгээдийн эд хөрөнгийн байдлыг харгалзах нь эл ялыг зөв хэрэглэх, биелэлтийг хангах нэн чухал хэрэгцээ мөн” (С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, 2019) гэж онцлон тэмдэглэж байжээ. “Шүүх торгох ялын хэмжээг тодорхойлохдоо үйлдсэн гэмт хэргийн хөнгөн, хүнд гэм буруутай этгээдийн болон түүний гэр бүлийн эд хөрөнгийн байдлыг заавал харгалзан үздэг байсан заалтыг 2002 оноос хүчингүй болгосноос” (С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 2018, хууд. 424) шалтгаалж төлбөрийн чадваргүй этгээдэд торгох ял оногдуулах тохиолдол амьдралд цөөнгүй гарч байна. Гэхдээ торгох ял бол гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үйлдсэн гэмт хэргийн хор уршгийг ухамсарлах, хохирлыг барагдуулах зэрэг олон ач холбогдолтой ялын төрөл юм.

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ял оногдуулж буй практик туршлагыг сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулан авч үзье. Үүнд:

Зураг. 1. “Монгол Улсын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс оногдуулсан ялын 2018-2022 оны харьцуулалт” (ШШГЕГ, 2018-2022)



2018 онд 12.381 хүн ял шийтгүүлж 7437 буюу 60 хувь, 2019 онд 13.621 хүн ял шийтгүүлж 7533 буюу 55.3 хувь, 2020 онд 14.078 хүн ял шийтгүүлж 54.3 хувь, 2021 онд 11.779 хүн ял шийтгүүлж 6179 буюу 52.4 хувь, 2022 онд 14492 хүн ял шийтгүүлж, 7883 буюу 54.3 хувь нь тус тус торгох ялаар шийтгүүлсэн байна.

Энэхүү ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, хугацаа тогтоож хорихгүйгээр торгууль ногдуулах замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өмчлөх эрхэд тодорхой хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгжиж, торгох ялыг эс биелүүлэх буюу зайлсхийх тохиолдолд хорих ялаар солих хууль зүйн үр дагавар үүсдэг тул харьцангуй биелэлт өндөртэй ял гэж үзэж болох юм.

Торгох ял нь хуулийн этгээд болон хувь хүний үйлдсэн гэмт хэрэгтэй хууль зүйн хувьд шалтгаан ба үр дагаврын холбоог үүсгэж, улмаар энэ ялыг оногдуулах нь зохимжтой агаад эрүүгийн хариуцлагын нийтлэг цээрлүүлэх, нийгэмшүүлэх, эрх сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг ялын зорилгыг хангахад чиглэсэн эрүүгийн эрх зүйн шударга, энэрэнгүй, тэгш, хууль ёсны ял гарцаагүй байх зарчмуудад үндэслэж байна.

ДҮГНЭЛТ

Торгох ял нь эрх зүйн зохицуулалтын хувьд эрүүгийн уламжлалт хууль, тогтоомжуудад зохицуулагдан өнгөрсөн түүхийн цаг хугацаанд хөгжиж, шинэчлэгдэн ирсэн ялын нэг үндсэн төрөл юм.

Энэхүү ялын зорилго нь ялтны эд хөрөнгөд хязгаарлалт хийх замаар түүнд эдийн засгийн дарамт үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, улмаар хууль зөрчих үйлдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг. Тухайлбал, шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу ялтнаас мөнгөн төлбөрийг албадан гаргуулах, буцаан төлөгдөхгүй байдлаар төрийн өмчлөлд шилжүүлдэг байна.

2015 онд батлагдсан шинэ Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд торгох ялын талаар хэд хэдэн шинэ зохицуулалттайгаар шинэчлэгдэж хэрэглээний цар хүрээ тэлж, агуулга нь сайжирсан. Тухайлбал, хуулийн этгээдэд торгох ял оногдуулах боломжийг нээж өгсөн нь уг ялын хэрэгжилтийн цар хүрээ, хэрэглээ нэмэгдэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн.

Үүнтэй холбогдуулан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хяналт, шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг цаашид улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

САНАЛ

Торгох ялыг 3 жил хүртэлх хугацаанд хэсэгчлэн төлж болохоор заасан нь өмнөх Эрүүгийн хуультай харьцуулахад ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлсэн боловч уг хугацааг тогтоохдоо ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох

боломжийг харгалзах учраас мөрдөн байцаалтын шатанд эдгээр асуудлыг заавал тогтоох арга ажиллагааг тусгайлан зааж өгөх;

Торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол төлөөгүй үлдсэн ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоногоор тооцож хорих ялаар солино гэж заасан нь эдлээгүй ялыг дүйцүүлэхээр байгаа бөгөөд биелэгдээгүй торгох ялын хэмжээнээс хамаарч Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг тухайн зүйлд заасан хорих ялын доод хэмжээ буюу 6 сараас доогуур хорих ял оногдуулах боломжтой байх тул энэ тохиолдолд хорихоос өөр төрлийн буюу нийтэд тустай ажил хийлгэх ялаар солих талаар зохицуулах;

Эрүүгийн хуулиар торгох ялыг 3 жил хүртэлх хугацаанд хэсэгчлэн төлөх боломжийг шүүхээс тогтоож өгөхөөр зохицуулсан ч шүүхээс тогтоосон хугацаа дуусах хүртэл огт төлөлт хийхгүй байгаа тохиолдолд торгох ялыг биелүүлээгүй гэж үзэх эсэх талаар тодорхой зохицуулаагүй байна. Өөрөөр хэлбэл шүүхээс тогтоосон хугацаа дууссаны дараа торгох ял биелэгдсэн эсэхийг тооцож үзэх, эсхүл тухайн хугацааны дотор огт төлөлт хийхгүй байгаа буюу хэсэгчлэн төлөхгүй байгаа тохиолдолд торгох ялыг биелүүлээгүй гэж үзэн хорих ялаар солих боломжтой эсэх нь тодорхойгүй байх тул энэ талаар зохицуулалт оруулах;

Хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялыг хэсэгчлэн төлүүлэхээр хугацаа тогтоох талаар хуульд заагаагүй бөгөөд торгох ялыг биелүүлээгүй тохиолдолд түүнийг хорих ялаар солих журмыг хэрэглэх боломжгүй байх тул эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна. (2017)

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

С.Жанцан. (2009). Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Улаанбаатар

С.Нарангэрэл. (2007). Эрүүгийн эрх зүйн гарын авлага. Улаанбаатар.

С.Нарангэрэл. (2018). Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Улаанбаатар.

С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган. (2019). Монгол Улсын Эрүүгийн эрх зүй үзэл баримтлал, уламжлал, сургамж. Улаанбаатар.

ШШГЕГ. (2018-2022). 2018-2022 оны жилийн эцсийн тайлан. Улаанбаатар.